



Published in the Russian Federation
Bulletin of the Kalmyk Institute for Humanities
of the Russian Academy of Sciences
Has been issued since 2008
ISSN: 2075-7794; E-ISSN: 2410-7670
Vol. 27, Is. 5, pp. 24–31, 2016
DOI 10.22162/2075-7794-2016-27-5-24-31
Journal homepage: <http://kigiran.com/pubs/vestnik>

UDC 94

A Historical Aspect of Mazan Baatar's Biography

A. Basang¹

¹ M. A., Assistant Lecturer, School of Mongolian Language and Culture, Northwest University for Nationalities (Lanzhou, People's Republic of China). E-mail: a.basang@163.com.

Abstract

With evidence from Russian and Oirat primary sources as well as the oral tradition, the article investigates the ancestry and clan history of Mazan Baatar and clears up some mistakes introduced by previous researchers. Apart from the fact that Mazan Baatar was actually a historical person, the statement found in some sources that his father's name was Öljeitü is wrong: a number of texts written in the Clear Script testify that the latter's name was Očir. Furthermore, Mazan Baatar was a relative of Ayuka Khan of the Torghuts. As reflected by Russian archival materials, he held the title 'Prince' and, thus, was a representative of the royal family of the Torghuts possessing a high social status in the Kalmyk Khanate. Members of the Erketen clan within the Volga Torghut Khanate were not mentioned as Mazan Baatar's subjects but had been first attested in the time of his great-grandfather, Cecen Noyan, and might have existed even earlier. Taking part in numerous wars and battles, Mazan Baatar spread the fame of his clan and got it deeply ingrained in the memory of the Oirat people so that even in the time of his son Yaman the Erketen clan retained its independence. After Yaman's death reported to have been Mazan Baatar's most eminent son, the internal turmoil, disputes and struggle for leadership among the nobility of the Torghut Khanate — which was aggravated by Russia's pressure — resulted in the fact that the Erketen clan was successively ruled by different nobles and, finally, became subject to Russia while some of its branches were absorbed by the diverse Kalmyk clans.

Keywords: Mazan Baatar, genealogy, ancestry, subjects.

Судалгааны үндсэн хэсэг

Торгуудчууд бол монгол туургатны доторх Ойрадын нэг салаа мөн. 17 дугаар зууны хориод оны үеэр торгуудын түрүү Хоо өрлөг угийн Зүүнгарын нутгаасаа салаад, казахын тал нутгийг өнгөрч, Урал мөрөн, Ижил мөрний өргөн уудам нутаг дэвсгэрийг эзэлж амьдрал. Түүний хойно Зүүнгарын нутгаас Дөрвөд, Хошууд, Өөлдүүд ирж тэдний бүрэлдэхүүнд орж Ижил мөрөн ба Дон мөрний хөвөө хязгаараар малжин амьдарч Торгууд хаант улсыг байгуулав. Торгуудын Шүхэр дайчингийн үеэс аван Аюк хааны цаг үе хүртэл торгууд хаант улс нь аж ахуй, улс төрийн талаар нилээд хүчирхэг улс байв. Мазан баатар бол энэхүү торгууд хаант улсын Шүхэр дайчин хааны цаг үеэс

аван Аюк хааны цаг үе хүртэл амьдарч байсан бөгөөд тэдний хамгийн шилдэг баатрын нэгэнд тооцогдож байсан хүмүүн болно. Зарим эрдэмтнээс Мазан баатрын амьдарч байсан цаг үе ба намтар түүхийн тухай адил бус үзэл баримтлалаа дурдаж өнгөрсөн юм. Үүнд: Ц. Төлөмжцэцэгээс «Аюк хаанаас Астрахань мужийн цэрэг, засгийн ноёдуудад явуулсан бичгүүдийн тухай» гэх өгүүлэлдээ Аюк хаан болон түүний сайд түшмэлүүдийн 1714–1724 оны хоорондох захидал харилцааны бичгүүдийн нэг хувь тод монгол үсгийн захидалд суурилж «баянголд марал чих гэсэн морины үүлдэр байдаг. Торгуудын дотор Мазаны тухай түүхэн дуу болон домог байдаг. Тус бичгээс үзвэл түүхэнд Мазан хэмээсэн

үнэн хүмүүн байж, Аюк хааны элчээр Орост очиж байжээ» [Төлөмжцэцэг 2015: 57] хэмээн энэхүү Аюк хаанаас астрахань мужийн цэрэг засгийн ноёдод өгсөн захидал бичигт гардаг «элч Мазан»-г халимаг ба Шинжааны Ойрад монголчуудын домог дурсамжийн түүхэнд арвин гардаг «манай тохой нутагтай, марал чихэн адуутай, манай ноён Мазан баатар» буюу торгууд хаант улсын түүхэнд нэр нөлөөтэй явсан Мазан баатартай нэг хүмүүн хэмээн эндүүрч буруу тайлбар хийж өгүүлсэн байна. Мазан баатрын тухай одоохондоо олдож байгаа хамаг анхны мэдээлэл нь Москвагийн Үндэстэний Архивт хадгалагдаж буй «1661 оны 11 сарын 20-ий өдөр, оросын зуутын толгойлогч Г. Голоццофийн халимгийн тайж нарын тухай бичиг» [Самоковасова 1901: 460] юм. Энэхүү 1661 оны Оросын данс архивын материалд Мазан баатрыг «тайж» цолтой хүмүүн байсан гэх мэдээлэл болон Москвагийн Үндэстэний Архивт хадгалагдаж байгаа Мазан баатрын нас барсантай холбогдох хоёр хувь тод монгол үсгийн захидал бичиг [Бичеев] болон герман улсын эрдэмтэн П. С. Палласын номд «1683 оны 8 сарын сүүлчээр Урал мөрний казак нь Мазан баатрын нутаг уруу гэнэтийн их дайралт хийх үес Мазан баатар хүнд шархадсан байна. Хэдэн өдрийн дараа шархнаасаа болж Урал мөрний Яик хотод нас барсан байна» [【德】P.S.帕拉斯著 2002: 68] гэж тэмдэглэснээс үзвэл Мазан баатар 17 дугаар зууны 80-аад оны эхний үе хүртэл амьдарч байсан нь тодорхой байна. Иймээс дээрх оросын архивын материал болон П. С. Палласын тэмдэглэл дахь Мазан баатар ба Аюк хааны 1714–1724 оны хоорондох захидал харилцааны бичигт гардаг «элч Мазан» бол нэг цаг үеийн хүмүүн биш байсан гэдэг нь тодорхой юм. Ийнхүү бид Ойрад монгол ба оросын түүх бичлэг хийгээд аман уламжлалын материалд суурилж Мазан баатрын удам угсаа болон харъяат ястаны ирэл гаралд холбогдох асуудлыг сүвэгчилье.

Мазан баатрын удам угсааны учир

13 дугаар зууны үеийн сурвалж бичиг болох «Монголын Нууц Товчоон»-оос нааших «Алтан товч», «Эрдэнийн товч», «Шар тууж» зэрэг олон сурвалж бичгүүдэд монголын хаад ноёдын уг язгуурыг бичиж тэмдэглэсэн зүйлс олон бий. Монголчуудын язгуур сэтгэлгээнд «хүмүүн гэж төрөөд, уг удмаа мэдэхгүй бол хээрийн сармагчныг гүйцэхгүй» хэмээн өөрийн уг язгуурын

түүх цадигаа бичиж тэмдэглэдэг уламжлал заншил орчин үе хүртэл уламжлагдсаар ирсэн ба одоо ч уламжлагдаж бий. Ойрад монголын түүх бичлэг ба дурсамж тэмдэглэлүүдэд Мазан баатрын уг язгуурын тухай тэмдэглэсэн зүйлс өдгөө хүртэл цөөн бус үлдэж иржээ. Энэ тухай холбогдол бүхий түүхэн сурвалжийг үндэслэвэл:

1. Хошууд ноён Баатар Увш Түмний туурвисан «Дөрвөн Ойрадын түүх» хэмээх тод үсгийн сударт «Бойгу Өрлөгийн хоёрдогч хөвгүүн Буур, эдний хөвгүүд Цэцэн ноён, Өвүүн тайш, Далай цорж, ноён Убаши энэ дөрвөн. Цэцэн ноёны хөвгүүн Мамзушир, Асмана овог, Архлан ахт, Бөх Ахарай, Дүнихэй, Эцес хүлгэн, Евел, Далай Увшай, Чин. Архлан ахтын хөвгүүн Очир, Диваан, Хай, Хулхай. Очирын хөвгүүн Мазан. Эдний хөвгүүн Яман...» [Дамбийпэлжид, Лижээ 2008: 140–141] гэж тэмдэглэжээ. Энэхүү үе залгамжийн тэмдэглэлийг зурваслаж үзүүлбэл: «Бойгу өрлөг — Буур Цэцэн ноён — Архлан ахт — Очир — Мазан — Яман» болно.

2. Дундад улсын Шинжааны Ховогсайраас олдсон «Гаван Шаравын тууж хэмээх оршивой» хэмээх тод үсгийн сударт: «...Бойгу өрлөг <...> хоёрдугаар Буурын дөрвөн хөвүүн, их нь Цэцэн ноён, Өвгүй тайш, Далай цорж, ноён Увш. Цэцэн ноёны арван гураван хөвгүүн. Их нь Мамзушир, Асам, Аваг, Архал, Ахт, Бөх хайран, Тенс Мэргэн Тэвнэ, Дурал дайчин, Цөхдий. Ахтын хөвгүүн Очирой, Диван, Нарихулахай гурван. Очиройн зургаан хөвгүүн, их нь Мазан. Мазаны дөрвөн хөвгүүн, их нь Яман. Ямны гураван хөвгүүн... Буурын уг Яман» [Бадай, Алтан-Оргил 1987: 246] гэж тэмдэглэжээ. Үүнийг зурваслаж үзүүлбэл: «Буур Цэцэн ноён — Ахт — Очирой — Мазан — Яман, Ямны гурван хөвүүн» болно.

3. «Гаван шаравын тууж»-ийн өөр нэг тод монгол үсгийн судар нь Оросын Санкт-Петербургийн Дорно дахины салбарын Голстунскийн Архивт хадгалагдаж байсныг Монгол Улсын эрдэмтэн, академич Б. Ринчен Ленинградаас тус сурвалжийн гэрэл зургийн хуулбар эхийг олж, 1967 онд Улаанбаатарт латин галигтай хамт гэрэл зургийн эхийг нь хэвлүүлжээ. Тус сурвалж бичигт: «... Бойгу өрлөг <...> Бойго өрлөгийн хоёр гэрийн хөвүүн <...> хоёр ану Буур <...> Буурын дөрвөн хөвүүн. Их нь Цэцэн ноён, Өвгүй тайш, Далай гурван хөвгүүн. <...> Буурын уг Яман» [Дамбийпэлжид, Лижээ

2008: 160–161] хэмээн тэмдэглэжээ. Энэхүү сурвалж бичигт Бойгу өрлөгөөс эхлэн Цэцэн ноён хүртэл бичиж тэмдэглэсэнээс бус, харин Мазаны тухай тэмдэглэсэн зүйлс ор мөр үгүй. Гагц буурын уг Яман гэж Мазаны хүүгийн нэрийг бичиж үлдээжээ.

Түүх нь өнгөрсөнд бий болсон хэрэг явдал хийгээд түүний явцыг заадаг болохоор бусдач байдаг боловч түүний түүх бичлэг нь харин биеч байдаг. Дээрх дурдсан Санктпетербургийн Дорнодахины салбар архивт хадгалагдаж буй «Гаван шаравын тууж»-д Бойгу өрлөгөөс эхлэн Мазаны элэнц өвөг Цэцэн ноён хүртэл тэмдэглэжээ. Харин «Хошууд ноён Баатар Увш түмний туурвисан Дөрвөн Ойрдын түүх»-д «Бойгу өрлөг — Буур Цэцэн ноён — Архлан ахт — Очир — Мазан — Яман» хэмээн Бойгу өрлөгөөс Яман хүртэл тэмдэглэсэн байхад, Хувагсайраас олдсон «Гаван шаравын тууж хэмээх оршивой»-д «Бойгу өрлөг — Буур цэцэн ноён — Ахт — Очирой — Мазан — Яман, Ямны гураван хөвгүүн» гэж Бойгу өрлөгөөс Яман, тэрчлэн Яманд гураван хөвгүүн байсан хэмээн тэмдэглэж буй. Дээрх түүх бичлэгүүдээс бид Мазаны эцэг нь Очир, тэрчлэн Мазанд Яман гэдэг хүү байсан мэдээллийг олж болно. Халимаг ба шинжааны ойрдын дунд тархсан «Мазан баатрын тууж», «Мазан баатар», «Ноётны тууж» зэрэг домог яриануудад Мазан баатрыг «Очирын их толгой», «Очирын Мазан» гэж өгүүлэх мөртөө «Мазан баатар» гэх түүхэн дуунд «Эрхэнийн шийр зуслантай билээ, эмнэг зээрд адуутай билээ, эрх Яман хөвүүнтэй билээ, эрхтэний ноён Мазан баатар» [Оконов 1989: 33] гэх буюу «Мазан баатрын шастир» гэх түүхэн дуунд «эрвэлсэн хүрэнтэй, эрх Яман хөвүүнтэй, Эрхтэний ноён Мазан баатар» [Церенов 1962: 69] хэмээн Мазан баатрын эцэг нь Очир гэдэг байсан жич түүнд Яман гэдэг хүү байсан хэмээн дурсаж дуулдаг нь дээрх түүх бичлэг лугаа тохиролцож бий. Гэхдээ халимагчуудын зарим домог дурсамжид Мазан баатрын эцгийн тухай арай өөр янзаар тайлбарласан байдаг. Тухайлвал, Мазан баатрын наймдугаар үе болох Таисия Сакиловна Тягиновагийн дурсамж тэмдэглэлд «Очирын Мазан гэж үгийн даршуулгаар хэлэгдсэн үг, юун гээд (яагаад — *шилэгч*) гэхүл Мазаны эцэг Өлзийт байсан болдог, Мазаныг бяцханд нь Өлзийт өнгөрч одсон юман, тэгээд Мазан авга Очироо түшээд, өссөн боссон болдог гэж миний бажэй (Тягиновын эцэг — *шилэгч*)

надад хэлж өгөхүл» [Тягинован 2011: 143] гэж тэмдэглэжээ. Бас халимгийн нэрт зохиолч Сайнбилэгийн Хасар (1909–1980)-ын «Заан бодон Мазан баатар» гэх түүхэн найраглалд «Өлзийт ноёны бүлд, өлгийлөх хөвгүүн төрүүш, үрүүд нь цугаар хүүхчүүд, үзэх зовлонд орхош <...> арван сар саатай, агын хөл жийжээ, хүзүүн тасрам хэлтэй, хүмүүн дандам толгойтой, хөвөрдөгөөрөө сараам алт, хөвүүн үрэн төржээ. <...> Өлзийт ноён өнгөрч, өнчрөөд хөвүүн нь үлдэнэ, омогтой тохмоос сөнгөрсэн, Очир авгадаа шүтнэ, Өлзийтийн уран „их толгойт“, өсөөд босоод явна» [Каляев 1962: 171] гэж тэмдэглэжээ. Эдгээр дурсамжид, Мазан баатрын эцэг нь Өлзийт гэдэг хүн байсан бөгөөд түүнийг бага байхад нас барсан тул авга Очирдоо асрагдаж өсчээ хэмээн дурсаж иржээ. Сайнбилэгийн Хасар бол «халимаг шүлэгчдийн дотроос „халимаг ардын шүлэгч“ хэмээх дээд цолыг хүртсэн хоёрдахь хүмүүн» [Каляев 1962] байсан юм. Иймээс Сайнбилэгийн Хасрын түүхэн найраглалд зохиолчийн бодгаль биеийн биеч нөлөө тусгагдсан нь яриан үгүй юм. Ердөө дурсамж нь бодитой оршихуй хийгээд биеч танилтын уялдаанаас бүрэлдсэн болохоор хоёрдахь шинж, зохиомол шинж, будлиант шинжийг бий болгодог. Ийнхүү «Гаван Шаравын тууж» болон «Хошууд ноён Баатар Увш Түмний туурвисан Дөрвөн Ойрдын Түүх» зэрэг түүхэн сурвалж хийгээд олонх аман уламжлалд Мазаны эцэг Очир гэж тодорхой тэмдэглэх буюу ярьж байхад, харин Таисия Сакиловна Тягинова болон Сайнбилэгийн Хасараас Мазаны эцэг Өлзийт хэмээн өгүүлсэн явдал нь дурсамжийн зохиомол шинж буюу будлиант шинжийг бий болгожээ. Иймээс зарим нөхцөлд түүхэн сурвалжийн тэмдэглэл үгүй бол дурсамж нь арай өвөрмөцөлсөн хандаштай болж хувирдаг байна.

Дээр өгүүлсэн Гаван Шарав ба хошууд ноён Баатар Увш түмний туурвисан түүх бичлэгт Мазан баатрын уг язгуурыг «Бойгу өрлөг» гэж тэмдэглэсэнээс үзвэл тэр нь Аюк хаантай уг гарал нэгтэй болохыг мэдэж болох юм. Учир нь «Бойгу өрлөгийн хоёр гэргийгээс гарсан зургаан хөвүүн, ах нь Зулзаган өрлөг, Буур, Горой, Мангай. Албат гэргийгээс нь гарсан нь Ул Цэнц, Булихан» [Дамбийпэлжид, Лижээ 2008: 29–30] гэж хошууд ноён Баатар Увш Түмний туурвисан «Дөрвөн Ойрдын түүх» гэх тод үсгийн сударт тэмдэглэжээ. Энэхүү

үе залгамжийн тэмдэглэлийг тодорхойлж үзүүлбэл «Бойгу өрлөг — Зулзаган өрлөг — Хоо өрлөг — Шүхэр дайчин — Пунцаг — Аюк» болно. Мазаны үе залгамжийг тодорхойлж үзүүлбэл «Бойгу өрлөг — Буур Цэцэн ноён — Ахт — Очирой — Мазан» болно. Үүнээс үзвэл Аюк болон Мазан баатар нь Бойгу өрлөгөөс салаад тавдугаар үе дээрээ яваа хүмүүс болно. Үүнээс үзвэл Мазан баатар бол торгуудын хаад язгууртны гаралтай хүмүүн байсан байна. Мазан баатрын торгууд хаант улсын түүхэн дахь нийгмийн зэрэг хэргэмийн тухай «Оросын Үндэстэний Эртний Архив баримтууд»-ын «Халимгийн хэрэг явдал» хэмээх хэсэгт «Мазан баатар тайс» (Мазан Батыр тайсе) [Рогожин, Батмаев 2003: 64], «Мазан баатар тайш» (Мазан Батыр тайша) «Музан баатар тайш» (Музан Батыр тайша) [Рогожин, Батмаев 2003: 87] гэх мэт түүний нэр болон зэрэг хэргэмийг хааяа адил бусаар тэмдэглэсэн боловч утгын хувьд нэгдэлтэй юм. Хураангуйлбал, Мазан баатар бол түүхт үнэн хүмүүн байсан мөртөө тод монгол үсгийн түүх бичлэг дахь тэмдэглэлээс үзвэл, Мазан баатрын эцэг нь Өлзийт биш, харин Очир гэдэг хүн байсаныг мэдэж болох юм. Үүнээс гадна оросын данс архивын материалд Мазан баатрыг «тайж» цол өргөмжилж явсан зэрэг материал сэлтээс ажиглавал Мазан баатар бол торгууд хаадын язгуур гаралтай хүмүүн байж торгууд хаант улсад онцгой нийгмийн байр суурьтай байсан гэдгийг мэдэж болох юм.

Мазан баатрын харьяат ястаны учир

Халимагт тархан дэлгэрсэн Мазан баатрын домог яриа хийгээд түүхэн дуунд түүнийг «Эрхтэний ноён Мазан баатар» гэх буюу эсхүл «Эрхтэний хөвүүн Мазан баатар» гэж торгууд хаант улсын эрхтэн аймгийн хүмүүн байсан жич тэр аймгийн ноён байсан гэдгийг илүү товойлгож ярьдаг. Харин Шинжаанд тархсан Мазан баатрын домог ярианд түүний ямар аймгийн хүмүүн байсан тухай өгүүлсэн зүйлс арай харагдах үгүй байна.

«Эрхтэн» гэдэг үгийг үгийн гарлын хувьд өөрөө эзэн мэдэх эрхтэй, чадалтай хүмүүн хэмээн үзэж болох юм. Ойрад монголчуудын олон аймаг угсаатан дотор эрхтэн гэдэг биеэ даасан ястан байсан нь түүхийн сурвалж бичигт ч тэмдэглэгдсэн байдаг. Жишээлбэл, «Зүүнгарын хаант улсын отог ба жасын тоо бүртгэлийн хүснэгт»-д: «Эрхтэн отог (ястан буюу аймаг 焮 — *шилэгч*) нь нэг зайсантай,

таван мянган эрээтэй, хүрдийн зүүн хойт даруй Бадхаш нуурын өмнөх төвлөнд нутаглаж байжээ» [【法】伯希和著1994: 57–66] хэмээн тэмдэглэжээ. Зүүнгарын хаант улсын Эрхтэн ястан нь 1757 оны манжийн хядлагад учран устгагджээ. Дараа нь манжийн дарлалаас зайлан Ижилд хүрсэн нь магад хэмээн зарим эрдэмтдээс судалсан байдаг [Лижээ 2008]. Гэтэл Мазан баатрын амьдарч байсан цаг үе нь 17 дугаар зууны үе болохоор зүүнгарийн хядлагын дараа ижилд хүрсэн эрхтэнтэй холбоо үгүй байх ёстой. Ийнхүү энд Мазан баатрын харьяатын хувиар илэрч байгаа «эрхтэн» хэмээх ястан нь Мазан баатрын хойчсын цаг үед хэрхэн захирагдаж байсаныг шинжлэх явдал болно.

Халимгийн түүхийн эрдэмтэн Авляевийн судалснаар, «халимаг дахь эрхтэн нь Мазан баатрын харьяат иргэний хувиар анх илэрсэн бөгөөд хожим Дондогомбо хаанд эзэмшигджээ» [Авляев 1994] хэмээн үзсэн нь арай буруу тайлбарласан ч болов уу? хэмээн бодож байна. Халимагийн ард иргэдийн аман түүхэд Мазан баатрыг эрхтэн аймгийн хүмүүн байсан хэмээн дурсаж ирсэн нь ч түүхийн үндэслэл баримттай. Энэ тухай П. С. Палласын ижлийн торгуудчуудын дунд хийсэн хээрийн шинжилгээний материалд: «Бойгу өрлөгийн хоёрдугаар хөвгүүн Буур дөрвөн хөвгүүнтэй. Түүний ахмад хөвүүн Цэцэн ноён арван гураван эхнэр авч тоолш үгүй олон үр хүүхэдтэй болсон. Судар бичгүүдэд түүний аль нэг эхнэрээс төрсөн ахмад хөвгүүний нэрийг тэмдэглэж байдаг. Цэцэн ноён үхэсний дараа, олон хөвгүүд нь түүний улсыг туячин хувааж, уг улс нь тархан бутарсан байлаа. Эдгээр уян буурай, чадал тэнхээ үгүй жижиг ноёд эцэстээ арга бус Хоо өрлөг болон түүний залгамжлагчдыг дагаж, тэдний ноёрхлыг хүлээн таньжээ. Хоо өрлөг эдгээр ноёдыг түүний зайсан болгож, онц эрх соёрхосноос торгуудын дотор их эрхтэн хэмээх биеэ даасан нэг отог бүрэлджээ. Бөх, зайсан болон их олон ноёдын төрлийн угсааны энгийн хүмүүс ч гэсэн бүр энэ отгоос гаралтай юм. Энэхүү отгийн зайсан нь үе залгамжлах эрхэм дээд эрхтэй бөгөөд өөрийн аймгаа үр хүүхэддээ хуваан өгөх эрх мэдэлтэй байж, бусад ван ноёдтой адилган харьяат ардаа захирч байдаг. Бойгу өрлөгийн гуравдугаар хөвүүний хойчис бөх тайш хожим нь харьяатаа дагуулан Ижилд ирж Ижлийн торгуудад нийлжээ. Тус угсааны ноёд ядран доройтож, хүчирхэг их торгууд ноёдод эзлэгдэн, тэдний зайсан

болж, нөхцөл байдал нь дээрхтэй адил болжээ. Ингээд торгуудчуудын дотор бас нэг отог бүрэлдэж, тэднийг бага эрхтэн гэдэг болжээ» [【德】P.S.帕拉斯著2002: 59] гэжээ. П. С. Палласын тус мэдээллээс үзэхэд их, бага эрхтэн бол Хоо өрлөгийн дүү нараас бүрэлдсэн мөртөө их эрхтэн нь Мазан баатрын элэнц өвөг Цэцэн ноёны үед нэгэнт биеэ даасан ба аймгийн зайсан нь үе залгамжлах эрхэм дээд эрхтэй бөгөөд өөрийн аймгаа үр хүүхэддээ хуваан өгөх эрх мэдэлтэй байж, бусад ван ноёдтой адилган харьяат ардаа захирч байдаг хэмээн өгүүлжээ. Иймээс зарим эрдэмтдийн судалсан шигээр «Халимаг дахь эрхтэн нь Мазан баатрын харьяат иргэний хувиар анх илэрсэн» хэмээн үзсэн нь арай цаг үе, хүн харын хувьд зөрөөтэй болохыг дээр өгүүлсэн тэмдэглэл гэрчилж болох юм. Ийнхүү халимгийн эрхтэн нь хамаг анх Мазан баатрын харьяат иргэний хувиар илэрсэн биш, харин Мазан баатрын өвөг элэнц Цэцэн ноёны цаг үед оршиж байсан буюу эсхүл түүнээс өмнө байсан гэдгийг мэдэж болох юм.

Мазан баатар нас нөгчисний дараа, эрхтэн аймгийг түүний их хөвүүн Яман хамаарч байжээ. Тэрээр «Яман бол торгууд хаант улсын анхны зайсан мөртөө эрхтэн аймгийн анхны зайсан» [Бакунин 1995: 41] байв. «Аюк хааны цаг үед эрхтэн нь Яман, Дамиран, Хулхайч зайсан зэрэг ах дүү гурвын захиралд оржээ» [Бакунин 1995]. Б. М. Бакунины тэмдэглэлд: «Саратовоос өөд Терешка хэмээх гол дээр Христосын шашныг хүлээн авсан эрхтэний халимгууд тосгон байгуулав. Тэнд бас сүм байв. Эрхтэний тэргүүн зайсан Яманы дүү тосгоныг шатаагаад, Христосын шашинд орсон халимгийг өөрийн эрхшээлд оруулав. Оросын ноёд Аюк ханыг шүүмжилэв. Тэгэхэд эрхтэний ноёд өөрийн албатаа дураараа захирах эрхтэй гэж Аюк хариу өгөв» [Бакунин 1995: 29] хэмээн тэмдэглэжээ. Эдгээрээс үзэхэд Аюк хааны цаг үед эрхтэн нь Мазан баатрын их хөвүүн Яманы харьяанд багтаж, тэрээр өөрийн аймгийн хэрэг учрыг өөрөө шийдвэрлэдэг мөртөө өөрөө эзэн мэдэж хамаардаг байжээ. Үүнээс мөрдвөл, «Эрхтэн» аймгийн үүрэг нь П. С. Палласын өгүүлсэн шиг «Эрхэм дээд эрхтэй бөгөөд өөрийн аймгаа үр хүүхэддээ хуваан өгөх эрх мэдэлтэй байж, бусад ван ноёдтой адилган харьяат ардаа захирдаг» үүрэгтэй байсан гэдгийг улам нэг алхам мэдэжж болох юм. Аюк хаан таалал төгссны

дараа эрхтэн нь хааны хөвүүд Цэрэндондог болон үүний дүү Галданданзаны албат болж оржээ. Торгууд хаант улсад олон удаагийн дотоодын самуурал, эрх суурийн булаалдаан, хаад ноёдын солигдол зэрэг шалтгаанаас болж эрхтэн нь адил бус ноёдод ээлжлэн захирагдаж байжээ. Энэ тухай Б. М. Бакунины тэмдэглэлд: «1734 онд Дондогомбоос халимгийн тал нутагт гэнэт довтложээ. Түүн дотор эрхтэн (Яман болон бусад арван гурван зайсныг баривчилж, тэдний олонх нь шоронд нас баржээ. Яман түүнчилэн таалал болов), таван отог, хавчин, хөвүүн ноёдын зарим хэсэг нь нэгдэж нэгдэж, Дондогомбын харьяанд оржээ» [Бакунин 1995: 72] хэмээн тэмдэглэжээ. Ингээд торгууд хаант улсын түүхэнд биеэ даасан эрхтэн аймгийн нийгмийн байгууламжийн систем нь ч Ямны нас барахтай зэрэг Дондогомбо ханд эзэмшигджээ. Түүний дараа Дондогдаш хааны хөвүүн Увш хаан эрхтэнийг захирч байжээ. Энэ тухай Астрахань дахь халимгийн данс эвхмэлийн материалыг үндэслэвэл: «Уг нь хаант улсын ерөнхий захирагч (Увашийг хэлж буй — *ишлэгч*)-ийн халимаг улсаас салж одсон эрхтэнүүд, баруунууд, багууд одоо Ижил мөрөн уруу нүүдэлж малжихаа хойшуулсан буюу тэнд одооо бүр огоорч, гол гатлаж малжих дур үгүй болж одов» [Пальмов 1989: 137]. 1771 жилд торгууд болон хошууд аймаг Увш болон Цэвэгдоржийн дагуулгаар уугуул нутаг зүүнгар уруу нүүхэд эзэн үгүй үлдсэн эрхтэн аймаг хуучин бууриндаа үлдэж хоцроод, хамаг сүүлд нь Увш хааныг дагахаар бодоод үймээн гаргаж байжээ. Энэ тухай Пальмовийн тэмдэглэлд «Н. А. Бекетов дөрвөд улсад, ялангуяа эрхтэний улс (аймаг *火焰* — *ишлэгч*)-д үймээн гарсан баттай чимээг олж сонсосноос хойно, эдгээр улсуудын эзэн, зайсан ба лам нар үймээн гаргасан тэргүүн ялтан гэснийг олж мэдэж, 1771 онд зарлиг буулгаж байгаад Асрах, Маш, Жамъян, Дөрвөд улсын ноёрхогч бага Гэцэл зэрэг ноёд жич тэдгээр улсуудын нэр хүндтэй зайсан ба эрхтэн улсын зайсан нарыг орос халимгийг хольж бүрдсэн цэрэг дотор оруулж Алексей Дондуков гүн хэргэмтэнд захируулаад Кубаний татаруудад хайлуулав» [Пальмов 1989: 185] гэжээ. Эрхтэн отог нь оросыг таалан дагаж хирс (Христосын шашны загалмай — *ишлэгч*) зүүсэн Алексей Дондуков (Дондогомбо хааны Кабардан Зан хатнаас төрсөн хүү)-ын захиралд орж

байснаа сүүлд нь «Алексай Дондуковын ач үр нь гал хонин жил (1787 он)-д Мүгелева хэмээх мужид орос албат нар аваад уг албат эрхтэн, бага цоохор хоёрыг шанд өгвэй. Тэр мэт бага цоохор, эрхтэн хоёр улс ану өөрийн ноёнд ноёлуулахаа огоороод, анхан оросын шанд орж одсон нь энэ мөн» [Дамбийпэлжид, Лижээ 2008: 78–79] хэмээн «Халимаг хаадын туужийг хурааж бичсэн товч оршивой» хэмээх тод монгол үсгийн сударт тэмдэглэжээ. Эрхтэн аймгийн зайсангууд ингэж үймээн шуугиан дэгдээж байсныг Астраханий захирагч Бекетовийн зарлигаар хориглож эрхтэн аймгийг өөр нутаг руу шилжүүлээд, шинэ газар оронд нүүлгэжээ. Энэ тухай тодруулж өгүүлэхэд «800 шахуу өрх эрхтэний улс Жамъяны хошууд улсад ирэв. Яргачин эрхтэн гэдэг отог их цоохор нутагт оров. Хавчин ангийн 30 шахуу өрх бүл бага дөрвөд нутгийн авганар аймагт тусав, зургаадагч анги нь болов. Тэн гол (Дон мөрөн- — *шилэгч*)-ын хөвөөнд Бозов дотор эрхтэний болон багуудд хоёр аймаг хэзээнээс аван байдаг мөн. Яман зайсангийн цагаас аван эдэн салаад, Хазах улс болов» [Авляев 1990] хэмээн эрхтэн нь уулын торгууд хаант улсын үеийн биеэ дааж эрх мэддэг чухал нэг аймаг байснаасаа оросын ноёдын захиралд хашигдаж сүүлдээ нэг хэсэг нь шууд оросын харьяанд орж, нэг хэсэг нь халимаг ноёдын харьяанд орсон буюу халимгийн торгууд, хошууд, дөрвөд, бозов аймгийн бүрэлдүүнд орж бутарсан байна.

Багцалбал:

1. Мазан баатар бол түүхт үнэн хүмүүн байсан мөртөө өнгөрсний хүмүүсийн дурсамж тэмдэглэл дахь Мазаны эцэг нь Өлзийт байсан гэдэг үзэлт нь буруу байж, Мазаны жинхэнэ эцэг нь Очир байсан гэдгийг тод монгол үсгийн түүх бичлэгүүд гэрчилж байх юм. Тэрчлэн Мазан баатар бол торгуудын Аюк хаантай нэг язгуур ястай хүмүүн байсан жич оросын данс архивын материалд Мазан баатрыг «тайж» цол өргөмжилж явсан гэдгээс үзвэл Мазан баатар бол торгуудын хаадын язгуур гаралтай хүмүүн байж торгууд хаант улсад нийгмийн байр суурь нь өндөр байсан гэдгийг мэдэж болох юм.

2. Ижлийн торгууд хаант улсын эрхтэн аймаг нь хамаг анх Мазан баатрын харьяат иргэний хувиар илэрсэн биш, харин Мазан баатрын элэнц өвөг Цэцэн ноёны үед анх илэрсэн буюу эсхүл түүнээс өмнө

оршиж байжээ. Мазан баатар олон дайн байлдаан дунд өөрийн аймаг ястныхаа нэр дуудуулж ойрадын ард иргэдийн ой цээжинд гүн шингэж түүний хүү Яманы үед ч эрхтэн аймаг нь өөрөө өөрсдийгөө эзэн мэдэж, өөрөө эрх дураараа албат иргэнээ хамаарч байжээ. Мазан баатрын их хөвүүн Яман таалал төгссөний дараа, эрхтэн аймаг нь торгуудын хаад ноёдын олон удааны дотоодын самуурал, эрх суурийн булаалдаан, хаад ноёдын солигдол жич цагаан хаант оросын гар дүрэлт зэрэг шалтгаанаас болж, эрхтэн аймаг нь адил бус ноёдод ээлжлэн захирагдаж хамаг сүүлд нь оросын харьяанд орох буюу эсхүл халимгийн олон аймаг ястаны дунд уусан шингэсэн байна.

Литература

- Авляев Г. О. Происхождение калмыцкого народа. Элиста: Калм. кн. изд-во, 2002. 325 с.
- Авляев Г. О. Эркетн улсин туужас // Хальмг үнн. 18.05.1990.
- Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ. Ойрад түүхийн сурвалж бичиг (тод монгол үсэг). Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1987. 442 с.
- Бакунин В. М. Описание калмыцких народов, а особливо из них торгоутского и поступков их ханов и владельцев. Элиста: Калм. кн. изд-во, 1995. 153 с.
- Бичеев Б. А. Тус материалыг Оросын Холбооны Халимаг Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны судлагч хангав.
- Дамбийпэлжид, Гэ. Лижээ. Монгол хятад харьцуулсан тод үсгийн ойрад монголын түүхийн сурвалж бичгүүд. Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2008. 269 с.
- Гэнээн Л. Шинжааны ойрадууд — түүх судлал. Улаанбаатар: Соёмбо принтинг хэвлэх үйлдвэр, 2008. 118 с.
- Каляев С. К. Антология калмыцкой поэзии. Элиста: Калмгосиздат, 1962. 300 с.
- Пальмов Н. Халимагчууд орост байсан үеийн түүхэн тойм (тод монгол үсэг). Урумчи: Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1989. 137 с.
- Посольские книги по связям России с Калмыцким ханством 1672–1675 гг. / сост. Рогожин Н. М., Батмаев М. М. Элиста: АПП «Джангар», 2003. 316 с.
- Самковасова Д. Я. Акты московскаго государства изданные императорскою академьею науки. Московский столь. 1660–1664. Санкт-Петербург, 1901. Т. 3.

- Төлэмжцэцэг Ц.* Аюук хаанаас астрахань мужийн цэрэг, засагийн ноёдод явуулсан бичгүүийн тухай // Ойрад монголын түүх соёлын асуудлууд. Улаанбаатар, 2015. С. 57.
- Төрскн назрин дуд / сост. и авт. вступ. ст. Б. Б. Оконов. Элиста: Калм. кн. изд-во, 1989. 318 с.
- Т. С. Тягинован амн урн үгин көрнгэс. Фольклорные материалы из репертуара Т. С. Тягиновой. Самозапись 2004–2010 гг. / предисл. Н. Г. Очировой, сост., коммент. Б. Б. Горяевой. Элиста: КИГИ РАН, 2011. 208 с.
- Церенов В. З.* Эркетени: Земля и люди. Из истории Черноземелья. Элиста: АПП «Джангар», 1997. 556 с.
- 【德】P.S.帕拉斯著：内陆亚洲额鲁特历史资料，云南人民出版社，昆明，2002. 228 с.
- 【法】伯希和著：卡尔梅克史评注，中华书局，北京，1994. 216 с.
- References**
- Avlyayev G. O. *Proiskhozhdenie kalmytskogo naroda* [The origins of the Kalmyk people]. Elista, Kalm. Book Publ., 2002, 325 p. (In Russ.).
- Avlyayev G. O. *Erktne ulsin tuuzhas* [Excerpts from the history of the Erketen clan]. *Khalimag Ünen* [Kalmyk Truth newspaper], 18 May 1990 (In Russ.).
- Baday, Altan-Orgil, Erdene. *Oyirad tüükhiyn survalzh bichig (tod mongol üseg)* [Oirat historical sources (in western Mongolian Clear Script)]. Urumqi, Xinjiang People's Publ. House, 1987, 442 p. (In Oirat-Kalm.).
- Bakunin V. M. *Opisanie kalmytskikh narodov, a osoblivo iz nikh torgoutskogo i postupkov ikh khanov i vladel'tsev* [Description of the Kalmyk peoples, in particular, Torghut people, and deeds of their khans and landlords]. Elista, Kalm. Book Publ., 1995, 153 p. (In Russ.).
- Bicheev B. A. *Tus materialyг Orosyn Kholboony Khalimag Ulsyn Niygmiyn Shinzhlekh Ukhaany sudlagch khangav* [Private research materials of the scholar from the Republic of Kalmykia (Russia)].
- Dambiyelzhid, Ge. Lizhee. *Mongol khyatad khar'tsuulsan tod üsgiyñ oyirad mongolyn tüükhiyn survalzh bichgüüd* [Oirat historical sources written in the Clear Script in comparison with corresponding Chinese and Mongolian compositions]. Urumqi, Xinjiang People's Publ. House, 2008, 269 p. (In Oirat-Kalm., Chinese, Mong.).
- Geeneen L. *Shinzhany oyiraduud — tüükh sudlal* [The Oirats of Xinjiang. Historical studies]. Ulaanbaatar, Soembo Printing, 2008, 118 p. (In Mong.).
- Kalyayev S. K. *Antologiya kalmytskoy poezii* [Anthology of Kalmyk poetry]. Elista, Kalm. State Publ. House, 1962, 300 p. (In Kalm. and Russ.).
- Palmov N. N. *Khalimagchuud orost baysan üeiyn tüükhen toym (tod mongol üseg)* [Essay on the history of the Kalmyk people within Russia's borders (in western Mongolian Clear Script)]. Urumqi, Xinjiang People's Publ. House, 1989, 137 p. (In Oirat-Kalm.).
- Posol'skie knigi po svyazyam Rossii s kalmytskim khanstvom 1672–1675 gg. / sost. Rogozhin N. M., Batmaev M. M.* [Ambassadorial books for Russia's relations with the Kalmyk Khanate, 1672–1675. Comp. by N. Rogozhin, M. Batmaev]. Elista, Dzhangar Publ., 2003, 316 p. (In Russ.).
- Samokvasova D. Ya. *Akty moskovskago gosudarstva izdannye imperatorskoyu akademiyeyu nauki. Moskovskiy stol'. 1660–1664* [Acts of Moscow state published by the Imperial Academy of Sciences. 1660–1664]. Saint Petersburg, 1901, vol. 3 (In Russ.).
- Tölömzhtsetseg Ts. *Ayuuk khaanaas astrakhan' muzhiyn tsereg, zasagiyn noedod yavuulsan bichgüüiyñ tukhay* [On letters submitted by Ayuka Khan to chiefs of the Astrakhan garrison, his own nobles and landlords]. *Oyirad mongolyn tüükh soelyn asuudluud* [Questions of the history of the Oirat Mongols]. Ulaanbaatar, 2015, p. 57 (In Mong.).
- Törskn hazrin dud / sost. i avt. vstüp. st. B. B. Okonov* [Songs of the Motherland. Comp. and introd. by B. Okonov]. Elista, Kalm. Book Publ., 1989, 318 p. (In Kalm.).
- T. S. *Tyaginovan amn urn ügin көрнгэс. Fol'klornye materialy iz repertuara T. S. Tyaginovoy. Samozapis' 2004–2010 gg. / predisl. N. G. Ochirovoy, sost., komment. B. B. Goryaevoy* [Folklore materials from T. Tyagina's repertory. Records of 2004–2010. Introd. by N. Ochirova, comp. and comment. by B. Goryaeva]. Elista, Publ. Dept. of Kalmyk Inst. for Humanities of the RAS, 2011, 208 p. (In Kalm. and Russ.).
- Tserenov V. Z. *Erketeni: Zemlya i lyudi. Iz istorii Chernozemel'ya* [The Erketens: land and people. Excerpts from the history of Chernozemelie]. Elista, Dzhangar Publ., 1997, 556 p. (In Russ.).
- 【德】P.S.帕拉斯著：内陆亚洲额鲁特历史资料，云南人民出版社，昆明，2002. 228 p.
- 【法】伯希和著：卡尔梅克史评注，中华书局，北京，1994. 216 p.

УДК 94

Мазан баатарын намтар түүхийн шинжлэл (Биография Мазан батыра и исторический аспект)А. Басан ¹

¹ преподаватель, Северо-Западный Университет национальностей (Ланьчжоу, Китай). E-mail: a.basang@163.com.

Аннотация. Тус өгүүлэлд орос ба ойрдын түүх бичлэг жич аман уламжлалын материалд суурилан, Мазан баатрын удам угсаа хийгээд харьяат ястныг судлан шинжлэхийн зэрэгцээгээр өнгөрсний эрдэмтдийн Мазан баатарт холбогдох зарим ойлголт танилтын эндүүрэлд залруулга хийсэн байна.үүнд Мазан баатар бол түүхт үнэн хүмүүн байсан мөртөө өнгөрсний хүмүүсийн дурсамж тэмдэглэл дахь Мазаны эцэг нь Өлзийт байсан гэдэг үзэлт нь буруу байж, Мазаны жинхэнэ эцэг нь Очир байсан гэдгийг тод монгол үсгийн түүх бичлэгүүд гэрчилж байх юм. Тэрчлэн Мазан баатар бол торгуудын Аюк хаантай нэг язгуур ястай хүмүүн байсан жич оросын данс архивын материалд Мазан баатрыг «тайж» цол өргөмжилж явсан гэдгээс үзвэл Мазан баатар бол торгуудын хаадын язгуур гаралтай хүмүүн байж торгууд хаант улсад нийгмийн байр суурь нь өндөр байсан юм. Ижлийн торгууд хаант улсын эрхтэн аймаг нь хамаг анх Мазан баатрын харьяат иргэний хувиар илэрсэн биш, харин Мазан баатрын элэнц өвөг Цэцэн ноёны үед анх илэрсэн буюу эсхүл түүнээс өмнө оршиж байжээ. Мазан баатар олон дайн байлдаан дунд өөрийн аймаг ястныхаа нэр дуудуулж ойрадын ард иргэдийн ой цээжинд гүн шингэж түүний хүү Яманы үед ч эрхтэн аймаг нь өөрөө өөрсдийгөө эзэн мэдэж, өөрөө эрх дураараа албат иргэнээ хамаарч байжээ. Мазан баатрын их хөвүүн Яман таалал төгссөний дараа, эрхтэн аймаг нь торгуудын хаад ноёдын олон удааны дотоодын самуурал, эрх суурийн булаалдаан, хаад ноёдын солигдол жич цагаан хаант оросын гар дүрэлт зэрэг шалтгаанаас болж, эрхтэн аймаг нь адил бус ноёдол ээлжлэн захирагдаж хамаг сүүлд нь оросын харьяанд орох буюу эсхүл халимагийн олон аймаг ястаны дунд уусан шингэсэн байна.

Ключевые слова: Мазан баатар; удам угсаа; харьяат ястан.